

ТОМУУГИЙН А(Н1N1)2009 ЦАРТАХЛЫН МОНГОЛ ДАХЬ ХОЁРДАХЬ ДАВАЛГАА

П.Нямдаваа

*Монголын анагаах ухааны академи,
Халдварт өвчин судлалын үндэсний төв*

THE SECOND WAVE OF THE INFLUENZA A(H1N1)2009 PANDEMICS IN MONGOLIA

(Short communication)

P. Nymadawa

*Mongolian Academy of Medical Sciences,
National Center of Communicable Diseases*

Influenza A(H1N1)2009 strain caused pandemics worldwide has been introduced in October 2009 into Mongolia and replaced by influenza B virus in February 2010 and A(H3N2) virus in October 2010. A new variant of pandemic A(H1N1) virus has been revealed in Mongolia in January 2011 and has been in a short circulation causing a minor epidemics. All 8 segments of a representative strain of this virus have been sequenced fully and deposited into GenBank. The study is continuing.

Pp. 117, Figure 1, References 7

2009 оны 4 дүгээр сард Америк тивд анх илэрч, Дэлхий нийтийг бүхэлд нь хамарсан томуугийн А(Н1N1)2009 вирусээр сэдээгдсэн шинэ цартахал Монгол улсад хожуухан (2009 оны 10 дугаар сараас) эрчимтэй тархаж, уг вирусийн орчил 2010 оны 2 дугаар сараас томуугийн В вирусээр бүрэн солигдсон хийгээд уг дэгдэлтийн эпидемиологийн болон вирус судлалын дүр төрх, эмнэлзүйн илрэл, цартахлын эсрэг авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний үр дүнгийн тухай бид өмнө нь нийтлүүлсэн билээ [1-4].

Томуугийн цартахлын вирус Дэлхий дахинд үргэлжлэн тархсаар байсан [5] боловч Монгол улсад уг вирусийн орчил 2010 оны 2 дугаар сард бүрэн зогсож, эхлээд (2010 оны 5-19 дэхь 7 хоногт) томуугийн В вирусээр, дараа нь (2010 оны 43-53 дахь 7 хоногт) томуугийн А(Н3N2) вирусээр солигдсон юм (Зураг 1.1. ба 1.2. Арын хавтасны дотор талд).

2011 оны эхнээс томуугийн А(Н1N1)2009 вирус Монгол улсад дахин эргэлтэнд орсон боловч цартахлын эхний давалгаатай харьцуулахад 3-4 дахин бага хэмжээний дэгдэлт үүсгэж, богино хугацаанд эргэлтээс дахин гарсан болно (Зураг 1.1. ба 1.2. Арын хавтасны дотор талд).

Цартахлын хоёрдох давалгааг үүсгэсэн томуугийн энэ вирусийн төлөөлөл омгийн 8 сегментийн нуклеотидын дарааллыг манай вирус судлалчид тогтоож, GenBank-нд бүртгүүлсэн бөгөөд уг омгийн хемагглютинин нь 2009 оны цартахлын вирусийн эх омгийн нэг болох A/California/07/2009 (H1N1) омгийнхоос 2 байрлалд, тухайлбал 188 дугаар байрлалд серин нь треонинаар (S188T), 208 дугаар байрлалд "X" нь глутаминаар (X208Q) тус тус солигдсон мутацтай байв [6, 7]. Судалгаа үргэлжилж байна.

Номзүй

1. Бурмаа, А., Нямдаваа, П., Дармаа, Б. ба бусад (2010): Монгол улсад бүртгэгдсэн томуугийн А(Н1N1)2009 цартахлын эпидемиологийн төрх, Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл, 5(36): 2-6;
2. Нямдаваа, П., Энхсайхан, Д., Майцэцэг, Ч. ба бусад (2010): Монгол улсад бүртгэгдсэн томуугийн А(Н1N1)2009 цартахлын вирусийн молекул-генетикийн төрх, Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл, 5(36): 7-12;
3. Оюунчимэг, Ц., Хоролсүрэн, Н., Дармаа, Б. ба бусад (2010): Томуугийн А(Н1N1) үхалдварын эмнэлзүйн төрх, Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл, 5(36): 12-15;
4. Nymadawa, P., Burma, A., Darma, B. et al., (2011): The first wave of influenza A(H1N1)2009 pandemics in Mongolia, Influenza and Other Respiratory Viruses, v.5, Suppl.1: 163-165;
5. Нямдаваа, П. (2011): Томуугийн А(Н1N1)2009 цартахлын вирусийн орчил зогсоогүй байна http://www.flu.mn/mgl/index.php?option=com_content&task=view&id=613&Itemid=49;
6. Нямдаваа, П. (2011): Шинэомгийн хемагглютининий гений нуклеотидын дарааллыг тодорхойлж GenBank-нд бүртгүүлэв. http://www.flu.mn/mgl/index.php?option=com_content&task=view&id=621&Itemid=49;
7. Нямдаваа, П. (2011): Томуугийн вирусийн шинэ омгийн геном http://www.flu.mn/mgl/index.php?option=com_content&task=view&id=625&Itemid=49;